



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/228

Бат-Өлзий сум

Мотоциклийн хөдөлгөөнийг
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.4.3 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт цас орж халтиргаа гулгаа үүссэн тул замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдал, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын төвд 2024 оны 11 дүгээр сарын 27-оос 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг түр хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлгийг өгч, сурталчлах ажлыг цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сум Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

